

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 19

1. **“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-
ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ
Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./**

6 – 19

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 21-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 51 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Цогтбаатар, Х.Баттулга, Б.Заяабал;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж,
Х.Тэмүүжин;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан.*

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцэх асуудлын дараалалд орсон Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулахыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах асуудлыг хойшлуулахаар тогтов.

***Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн
байнгын хороонд хүргүүлнэ./***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх О.Машбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Ц.Эрдэнэбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга
Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг,
Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул,
Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх
Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын
гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод
хэргийн сайд О.Алтангэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн
бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Шүүхийн ерөнхий зөвлөлийн
дарга Н.Мөнгөнцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын
дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их
Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн
П.Сайнзориг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар
тогтов.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 42 минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж,
59.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
11 цаг 51 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны ирц бүрдсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Х.Баасанжаргал гишүүн ирсэн байна, М.Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна, О.Номинчимэг гишүүн ирсэн байна, С.Одонтуяа гишүүн ирсэн байна, У.Отгонбаяр гишүүн ирсэн байна, П.Сайнзориг гишүүн ирсэн байна, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Л.Соронзонболд гишүүн ирсэн байна, Г.Уянгахишиг гишүүн ирсэн байна, Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна, Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүд ирсэн байна.

Ирцдээ орсон гишүүдийг хуралдаа орж ирэхийг хүсье.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Хоёр.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? П.Сайнзориг гишүүн байна. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Өнөөдөр хэлэлцэх асуудал дээр хуульд заасан хугацаанд холбогдох Байнгын хороонд хүргүүлэх асуудал байгаа. Үүнийгээ хэлэлцээд явахыг дэмжиж байгаа.

Хууль тогтоомжийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэг сайн ажилласан байна. Тэгээд бас яах вэ зарим зүйлүүдийг тодруулах 4, 5 асуудал байна.

Хоёрдугаарт, яг энэ нэлээн зарчмын зөрүүтэй юмнууд хураагдаж байгаа учраас гол хууль санаачлагч Д.Цогтбаатар даргыг ирсний дараа үүнийгээ ярилцаад хэлэлцээд Хууль зүйн байнгын хороогоороо ирц өндөртэй байж байж энэ асуудлыг хэлэлцээд явъя гэж бодож байна.

Энэ өөрөө эргээд сүүлдээ бас зөв томъёолол, зохицуулалтыг нь хийж өгөхгүй бол институт хоорондын маргаанууд үүсэх ийм сонин байдал руу орох шинжтэй ийм зохицуулалтууд нэлээн байна. Зарим зүйлүүд нь ойлгомжгүй байдал руу орох.

Тэгэхээр гишүүдийг би энэ удаад Хууль тогтоомжийн хуулийг хэлэлцэх асуудлыг долоо хоногоор хойшлуулаад ирэх долоо хоногийн Хууль зүйн байнгын хорооны хурлаараа хууль санаачлагч ирэх байх. Тэр үед хэлэлцье гэсэн ийм горимын саналтай байна. Ийм горимын санал гаргаж байна.

Хууль тогтоомжийн хуулийг хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулъя гэсэн горимын саналтай байна.

Б.Энхбаяр: Гишүүдийг танхимд орж ирэхийг хүсэж байна.

Ирцдээ орсон гишүүд П.Сайнзориг гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан учраас зарчмын зөрүүтэй саналаар санал хураах учраас ирцдээ орсон гишүүдийг танхимдаа орж ирэхийг хүсэж байна. М.Нарантуяа-Нара гишүүн, О.Номинчимэг гишүүн, С.Одонтуяа гишүүн, Г.Уянгахишиг гишүүн нар орж ирээрэй. Орж ирэхээр нь санал хураа.

П.Сайнзориг гишүүний горимын саналаар өнөөдрийн хэлэлцэх асуудалд байгаа Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хууль санаачлагч, ахлагч, Байнгын хорооны даргыг байлгаж байж ярь. Бас асуудлууд тодотгох ийм зүйлүүд байна.

Манай П.Сайнзориг гишүүн бас яг хууль боловсруулах ажлын арвин их туршлагатай учраас гишүүний саналыг харгалзахгүй бол болохгүй байгаа юм гэдэг үндэслэлээр саналыг дэмжиж байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Энэ асуудал хойшлогдлоо.

Дараагийн асуудалдаа оръё.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

О.Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд. О.Алтангэрэл сайдыг дуудаарай. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг ирсэн байна. Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр ирсэн байна. Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа дарга ирсэн байна. Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх О.Машбат ирсэн байна. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм ирсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид ирсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Бадамсэрээжид ирсэн байна. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням ирсэн байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Л.Очирсүрэн ирсэн байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна уу? Надаар тасаллаа. Би асуулт асууя. Надаас өөр хүн алга байх шиг байна. Асуулт. Дараа нь үг юм байна. Үг бол тусдаа юм байна. Асуулт асууя. П.Сайнзориг гишүүн байгаа юм байна шүү. П.Сайнзориг гишүүнээр тасаллаа.

П.Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Ингээд жилийн хөгжлийн төлөвлөгөө орж ирж байгаа. Үүнтэй уялдуулаад бас ирэх жилийн төсөв боогдох учиртай.

Тэгээд энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор зарим тоо, статистикийг нэг асуухгүй бол болохгүй байгаа юм.

Түрүүн төрийн албан хаагчдын 9 хувиар цомхотгох асуудал бас яригдаад байгаа. Үүнийг ч гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг би ажиглаж үзсэн. Яг ямар арга зүйгээр цомхотгох гээд байгаа юм? Тэр зөвлөл ч юм уу? Эсвэл цомхотгох болсон үндсэн шалтгаан нь юу вэ гэдэг зүйлийг ерөөсөө ярихгүй байгаа.

Үнэхээр энэ цахимжилт сайжраад цомхотгох гэж байна уу? Эсвэл чиг үүргийн давхардлууд үнэхээр бий болчихоод байгааг хүлээн зөвшөөрөөд цомхотгож байгаа юу, үгүй юу. Энэ асуудал ойлгомжгүйжгүй байгаа.

Нэг тайлбар яваад байгаа. Багш, эмч нараас бусад салбар дээр цомхотголыг 9 хувь барина гэж байгаа юм. Энэ нь тэгээд яг хэдэн хувь байгаа юм?

Тэгээд энэ юунд нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд өртөх вий гэдэг дээр бас болгоомжлол байна. Гол нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны бүтэц данхайгаад л байгаа болохоос биш яг үндсэндээ үндсэн ажил хийдэг шүүгч нарын тоо бас нэмэгдэж өгөхгүй байна. Шаардлагагүй, ачаалалгүй байгаа хэсэг дээр орон тоог маш ихээр нэмж өгч байгаа хандлагууд байна. Жишээ нь, захиргааны давж заалдах шатны шүүх дээр нэг хэргийн хөдөлгөөнийг харахад жилдээ ерөөсөө 30 хүрэхгүй хэргийг шийдэж байгаа ийм ачаалалтай шүүх дээр 10 орон тоо жишээ нь нэмж өгч байгаа юм.

Тэгэхээр ийм байдлаар магадгүй хуваарилж өгсөн хүний нөөц, төсвийн хуваарилалтыг хийвэл энэ чинь бас олон нийтийн дургүйцлийг хүргэх нь ойлгомжтой байгаа юм.

Гэтэл иргэний шүүгч дутагдалтай байна. Эрүүгийн шүүгч дутагдалтай байна. Ийм байхад хүн хүч хүрэхгүй байгаа биш ийм захиргааны шүүх дээр 10 орон тоог нэмж өгөөд, ингээд шүүгч нарын сонгон шалгаруулалт. Бараг томилох гээд байгаа юм уу даа. Би тэгж ойлгосон. Тэгээд нэг ийм мөнгөний маргаан, тендер, тусгай зөвшөөрөл ярьдаг газар дээр ямар ашиг сонирхлоор ийм зүйл явагдаад байна. Би үүнийг тэгээд хардахаас өөр аргагүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ төрийн албан хаагчдыг цомхотгох асуудал дээр ямар зарчим, арга зүй барих гэж байгаагаа хэлээч.

Хоёрдугаарт, ер нь эрүүл мэнд болон боловсролын салбараасаа гадна яг доодох хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын гүйцэтгэх дээр буюу гүйцэтгэл дээр сууж байгаа, анхан шатны нэгж дээр сууж байгаа энэ чиглэлийг ерөөсөө цомхотгож болохгүй байх шүү. Харин магадгүй тэр захиргаа энэ тэртэй нь ярьдаг, хэлдэг юм байж болдог байх. Хуучин 20 хүрэхгүй хүнтэй ажилладаг байсан Шүүхийн ерөнхий зөвлөл чинь 200-аад хүнтэй болсон гэж сонссон. Ойлгомжгүй л байгаа юм. Тэгээд юу хийдэг юм бол. Тэгээд баахан АА-аар цалинждаг. Энэ Төрийн албаны тухай хууль дээр энэ төрийн албыг 4 ангилалтай байна гээд “АА” гэдэг зүйлээр 5 дахь ангиллын гаргаад ирсэн. Яг энэ цалингийн шатлалаараа тусдаа ангилалтай. Эд нар нь тусдаа горимоор явдаг. Энэ Үндсэн хууль зөрчсөн төрийн албанд байхгүй ангиллаар бий болгож.

Тэгэхдээ энэ бол цалингийн шатлал нэрээр тусдаа ангиллын бий болгосон. Ингээд ялгамжтай, ялгаварладаг. Энэ нь нөгөө төрийн албан хаагчдын албан хаагчдын орлогын тэгш бус зөрүүг үүсгэж байгаа юм.

Одоо “АА” ангилалд л орж чадахгүй бол. 2 сар хүрэхгүй байгаа шүү дээ. Тэгтэл “АА” ангилалд орсон. Энэ үлгэр жишээг жишээ нь манай Улсын Их Хурлын Тамгын газар өөрсдөө үлгэрлэх байтал өөрсдөө задгайг нь тавьж өгсөн л дөө. Өөрсдөө бүгд олоод “АА” болоод 4, 5 сая цалинг нь аваад. Араас нь Хэрэг эрхлэх газар орж ирээд л. Бүх ингээд улс төрчдийг лоббиддог институт нь ороод. Яг ажил нухдаг, цаас нухдаг төрийн захиргаа нь үлдсэн. Тэгээд тэд нарыгаа цомхотгоно гээд л бид хэд ярьж байгаа. Тэгэхээр энэ зүйл юу байна?

Хоёрдугаарт, энэ шүүх эрх мэдэл болон хууль сахиулах байгууллага нь цахимжилт жоохон хоцорчхоод байгаа. Энэ дээр нэгдсэн тийм хөрөнгө оруулалт... /минут дуусав/

Б.Энхбаяр: Эхлээд хэн хэн хариулах вэ? Өөрийгөө танилцуулаад. Сангийн яам уу? Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулна. Дараа нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг хариулна.

3 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар Ц.Эрдэнэбат. Гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны шинэчлэл бол энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөн дээр хэд хэдэн реформын ажлууд тусгагдсан явж байгаа. Та бидний бүгд мэдэж байгаагчлан 2025 оны эхний гүйцэтгэлээр манай орлого олдог гол эрдэс баялаг, түүхий эдийн үнэ огцом унасан. Мөн ер нь гадаад, дотоод нөхцөл байдал 2026 онд нэлээд бас тааварлашгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байгаатай холбоотойгоор шинэчлэл, реформуудыг заавал хийх ёстой байгаа юм.

Тэгээд яагаад хийх болсон тооцоолол нь эхний урьдчилсан судалгаа гараад явж байгаа. Сүүлийн 12 жилийн байдлаар төрийн албан хаагчдын тоо огцом өссөн ийм судалгаанууд гарч ирж байгаа.

Нийтээрээ 40 орчим хувиар өссөн юм байна. Түүн дотор

- ▶ улс төрийн алба 36.6,
- ▶ төрийн захиргааны алба 31.9,
- ▶ төрийн тусгай алба 70.5,
- ▶ төрийн үйлчилгээний алба 32.7 хувиар өссөн ийм судалгаа байгаа юм.

Тэгээд энэ нь төрийн албыг зүгээр цомхотгох, хэмнэх ийм агуулга биш. Чиг үүргийн оновчлол, үр ашгийн өсөлт, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, төсвийн сахилга зэрэг хослуулсан стратегийн реформ хийхээр зорьж байгаа юм.

Тэгээд Ерөнхий сайдын албан даалгаврын дагуу бид 3 шинэчлэлийн ажил хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ 2025 онд ур чадварын шинэчлэл буюу хүний нөөцийн стратеги гарах юм. Тэгээд энэ дээр гол зарчим болон агуулга нь болохоороо үүргийн давхардлыг арилгах, үйлчилгээний чанарыг бууруулахгүйгээр бүтцийн шинэчлэл хийх, цахим засаглалын бодлого, нийгмийн хамгаалалыг дэмжих системтэй уялдуулах гэх мэтчилэнгээр.

Тэгээд шинэчлэлийг хийхдээ дифференциал буюу чиг үүргийн шинжилгээнд суурилж хуваарилалтын дагуу хийхээр явж байгаа.

Тийм учраас энэ тооны цомхотголоос чанарын шинэчлэл рүү, давхардлыг арилгаж бүтцийн оновчлолыг сайжруулах, төсөв хэмнэхээс гадна төрийн институцийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх гээд чиг үүргийн дүн шинжилгээ хийх, процессыг нь дахин инженерчлэл хийх гэх мэтчилэнгээр ийм цогц байдлаар хийхээр урьдчилсан тооцоолж судалгаа явж байгаа.

Тэгээд үүнийг хийхийн тулд дараагийн хийх алхмууд нь нөгөө байгууллагуудаа ангилах, түүн дотор давхардлууд байх гэх мэтчилний шинжилгээнүүд хийх, шинэчлэлийг хийх чиглэлийг тодорхойлох. Тэгээд дунд шатны бүтэц, захиргааны ч гэдэг юм уу гэх мэтчилэнгээр. Орлуулах болон дэмжих арга хэмжээг тодорхойлох, цахим шинэчлэлт, нэгдсэн бүтэц, бүсчилсэн зохицуулалт, гэрээт үйлчилгээ гэх мэтээр.

Хүлээгдэж буй үр дүн, нөлөөллийн үнэлгээг тооцоолох. Үүний дагуу аргачлалын олон улсын сайн жишгүүд байдаг юм байна. Үүнээсээ үүдэлтэйгээр аль салбарт яг хэдэн хувь гэдэг тоо нь нарийвчилж гарч ирэх юм. Бид нарын урьдчилсан судалгааны үндсэн дээрээс эхний ээлжид 2026 онд 9 хувь гэдэг тоо гарч ирсэн юм. Тийм. Баярлалаа.

Б.Энхбаяр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг. Тодорхой тоо асуусан. Тийм ээ. Шүүгчийн ачаалалтай холбоотойгоор орон тоо нэмж байна уу? Ажил багатай шүүгч нар дээр олон орон тоо нэмж байна. Шүүхийн ерөнхий зөвлөл саяхан 20 хүний ажлын албатай байсан. Одоо 200 хүрчихлээ шүү гэдэг ийм асуудлыг П.Сайнзориг гишүүн асууж байна.

4 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг. П.Сайнзориг гишүүний сая асуусан давж заалдах шатны шүүхэд шүүгчийн сонгон шалгаруулалтыг зарласан байгаа. Одоо энэ дээр нийт давж заалдах шатны захиргааны хэргийн шүүхэд 10 шүүгчийн сул орон тоог сая 2025 оны нэг сард зарласан. Одоо манай 9 дэх удаагийн сонгон шалгаруулалт явагдаж байна.

Өмнөх сонгон шалгаруулалтад нийт 2500 иргэн нэр дэвшигч бүртгэгдсэнээс нийтдээ 109 шүүгчийг бид өргөн мэдүүлж томилж чадсан байгаа. Энэ удаагийн сонгон шалгаруулалтад тэр давж заалдах шатын шүүхэд ялангуяа асууж байгаа шүүхэд 9 орон тоо зарласнаас 5 хүн тэнцсэн байгаа. Одоогоор өргөн мэдүүлэх хугацаа арай болоогүй байна. Сонгон шалгаруулалт дуусаагүй явж байна.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нэмэгдсэн гэж байна. Шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь Шүүхийн ерөнхий зөвлөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг.

Тэгээд өмнө бол бид хэд бас шүүхийн бүтэц, орон тоог, Тамгын газрын бүтэц орон тоог баталсан. Үүн дээр ажлын албаны бүтцийг нийт 159 орон тоогоор баталсан. Яг одоогоор ажиллаж байгаа нь Шүүхийн ерөнхий зөвлөлд 109 орон тоотой ажиллаж байна. Яг 200 хүрсэн юм бол одоогоор байхгүй байна.

Тэгээд мөн түүнчлэн Шүүхийн тухай хуульд 2024 онд өөрчлөлт орсны дагуу 46.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчийн ажлын албан тушаал, цалин нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан орон тоонд төсвийн хүрээнд тогтоож нэмэгдэл олгох журмыг баталсан байгаа. Үүнтэй холбоотойгоор бид бас 2024 оны 11 сарын 28-нд энэ журмыг баталсан.

Тэгээд манай төсвийн тухайд сая хөгжлийн төлөвлөгөөний төсөлд бид яг тулгамдаад байгаа өөрсдийн асуудлууд дээр саналаа өгсөн байгаа. Нэгдүгээрт, 2024 оны шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах.

Үүнд шүүх анхан болон давж заалдах шатын шүүхийн авлига, албан тушаалын гэмт хэргийг шууд дамжуулахаар заасан байгаа. Үүнтэй холбоотой шүүх хурал хуралдааны танхимыг тохижуулах, тоног төхөөрөмжийн асуудлыг оруулж өгсөн. Энэ санал маань дэмжигдээд төлөвлөгөөнд орж байгаад талархалтай байна.

Хоёрдугаарт, шүүх цахимжуулалт нэвтрэх гээд. Одоо энэ цахимжуулалтын асуудлыг бид дэмжээд явж байгаа. Тэгээд энэ цахимжуулалт

нэвтрүүлэлтийг эхний ээлжид хялбар ажиллагааны шүүхээс, дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны тойргийн шүүхээс эхлэх ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Энэ төлөвлөгөөний дагуу энэ 6 сард багтаад цахимжуулалт нэвтрэх байх. Бусад шүүхийн тухайд 9, 10 сард нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Цахимжуулалт нэвтрүүлэхтэй холбоотойгоор тоног төхөөрөмжүүд бас шаардлагатай байгаа. Энэ тоног төхөөрөмжийн судалгаа, шаардлагатай тооцооллоо бид хүргүүлсэн байгаа.

Мөн түүнчлэн манай дээр бид нарын 2024 оны Шүүхийн тухай хуульд орсон нэг гол өөрчлөлт, зохион байгуулалт бол нөгөө шүүхийн зохион байгуулалт байгаа. 2026 оны 01 сарын 01-нээс Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулагдах ёстой. Үүнтэй холбоотойгоор барилга, мөн түүнчлэн тоног төхөөрөмж. Тэгээд... /минут дуусав/

Б.Энхбаяр: О.Алтангэрэл сайд нэмж хариулъя. О.Алтангэрэл сайдын микрофон.

О.Алтангэрэл: Энэ цахимжилттай холбоотой асуудал бол ер нь удаашралтай байгаа нь үнэн.

Тэгээд бид цахимжилттай холбоотой асуудал дээр цаашид анхаарах шаардлагатай. Хамгийн сүүлд гэхэд бид энэ Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цахимжилт дээр хамтарч ажиллая гээд. Бид GIZ[Gesellschaft für Internationale Zusammenarbeit]-тэй бас яриад. GIZ-ийнхэн бид бас наад цахимжилт дээр чинь оролцъё оо гээд.

Зөрчил дээр энэ цахимжуулалтын систем явж байгаа. Ер нь энэ цахимжилтын үйл ажиллагаа хууль сахиулах байгууллага, нэн ялангуяа манай энэ цагдаагийн байгууллагатай холбоотой хэрэг бүртгэл, мөрдөн шалгалтын ажиллагаатай холбоотой эрүүгийн хэрэгтэй холбоотойгоор цахимжилтын ажиллагаа нэлээн шаардлагатай байгаа.

Тэр орон тоотой холбоотой асуудал дээр бол бид байр сууриа тодорхой илэрхийлсэн. Өнөөдөр хууль сахиулагчдын орон тоо тэртээ тэргүй дутагдалтай байгаа. Аль болохоор захиргааны албан хаагчдыг цөөлөх, дарга нарын тоог багасгах энэ зүйл рүүгээ анхаараач ээ гэдэг ийм асуудлууд ярьсан. Тэгээд бас олон жил шүүмжлэлтэй явж ирсэн. Зарим нэг байгууллагуудын дэргэдэх энэ урлагийн чуулга зэргийг бас татан буулгаад үндсэн үйл ажиллагаанд оролцуулах чиглэлээр яв аа. Тэгээд баахан амжилт гаргадаг, гаргадаггүй нь мэдэгдэхгүй нэг баахан тамирчин, бөхчүүд цалинжуулаад, ажиллуулдаг. Үүнийг үндсэн ажил руугаа, эргүүлд гарах бол эргүүлд, хянагч хийх бол хянагч. Үндсэн ажил руугаа гэсэн ийм чиглэлүүд рүүгээ явж байгаа.

Хууль сахиулах байгууллагын хэмжээнд орон тооны хувьд хасах танах зүйл бид байхгүй гэдэг байр сууриа хатуу илэрхийлж байгаа. Цаашдаа харин шинээр нэмэгдэж байгаа чиг үүргүүд болон тухайлах юм бол энэ хорихоос өөр төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа жилээс жилд өсөж байгаа. Гүйцэтгэх хуудасны тоо асар их нэмэгдэж байгаа. Энэ чиглэл дээр нэмэгдүүлэх бодлого барихаас биш бид хууль сахиулах байгууллагын системийн хэмжээгээр орон тоо цомхотгох ийм асуудал огт байхгүй шүү гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би Эдийн засаг, хөгжлийн яаманд наад ярьж байгаа мэдээлэл чинь зүгээр ерөнхий мэдээлэл байна.

Тэгээд үүнийг дагасан төсөвт ямар ачаалал үзүүлэх гэж байгаа юм? Нэг удаагийн тэтгэмж өгөх гэж байгаа юм уу? Сая Америк бол гарч ирээд тэдэн сарын тэднээс ажлаа орхиж явна. Орхиж явж болно. Он дуустал цалинг чинь бүтнээр нь өгнө гэдэг зүйлийг хэлээд явж байгаа байхгүй юу.

Гэтэл бид зүгээр 9 хувийг танана л гээд байдаг. Ямар арга зүйгээр. Чиг үүрэг давхардсан юмнуудыг хэмнээд ингэж 9 хувь танах гэж байгаа юм гэж хэлэхгүйгээр ерөнхийд нь л нэг ийм урсгал зардлыг багасгана гэдэг юм яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр наадах чинь ерөөсөө аль нэг салбарыг заримдаа их хэлмэгдүүлэх юм болно. Тэнд функцийн хувьд ажиллах бололцоогүй болно.

Тэгэхээр чиг үүрэг давхардалтай хэсэг дээрээ. Энэ дээрээ тэтгэмж өгөх үү, үгүй юу гэдгээ тодорхой хэлчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт, Хууль зүй, дотоод хэргийн яам маань бас шүүх эрх мэдэл, энэ хууль сахиулах байгууллагын байгууллагын цахимжилтийг дэмжих нэг ерөнхий хууль оруулж ирээд нэгдсэн уялдаатай явахгүй бол газрын салбар дээр давтсаныг бид хэд давтах гээд байна аа? Угсрагддаггүй баахан тус тусдаа системүүдийг Ерөнхий зөвлөл нь ч яриад байдаг. Тэнд бүтээгдэхүүнээ... /минут дуусав/

Б.Энхбаяр: 3 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаад.

Ц.Эрдэнэбат: П.Сайнзориг гишүүний асуултад нэмж хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат.

Түрүүний хэлсэнчлэн энэ ингээд нэгдсэн цогц систем, стратеги явж байгаа.

Тийм учраас яг саяын таны хэлж байгаа аль аль нь хүчин зүйлсүүдийг тооцож байгаа. Ялангуяа давхардал арилгах, дээрээс нь төрийн чиг үүргийн бүрэн цогц шинжилгээ хийсний дагуу нэлээд төрийн үйлчилгээг одоо хийгдэж байгаачлан цахим болон e-mongolia болон бусад арга хэрэгслүүдийг ашиглаж хийгдэх боломжтой гэж тооцоо судалгаанууд гарч байгаа.

Яг аль салбар дээр хэдэн хувь гэдэг нь ахиж нарийвчилж судалж байж таны түрүүний хэлсэн тэр нийгмийн баталгааг нь яах юм, тэр Америкийн нөгөө DOGE /Department of Government Efficiency/ шиг эрт зарлах уу, үгүй юу гэдгийгээ одоо яг хэрэгжээд явж байгаа тэр ур чадварын шилжилт буюу хүний нөөцийн стратегийн энэ ажил маань 2025 онд хийгдэж байж гарах юм.

Одоогийн урьдчилсан тоо байгаа авч зарлах нь зохимжгүй гэж бид бас бодоод байгаа юм. Үл ойлголцол үүссэн. Дээрээс нь энэ тоо маань ахиад хэлэхэд урьдчилсан тоо. Яг эцсийн тоог нь Төрийн албаны зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтарч байж, эцэслэж байж. Дээрээс нь энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань Улсын Их Хурлаар батлагдмагц энэ ажилд нь бүр нарийвчлаад, энэ дээр хэд хэдэн Байнгын хороон дээр гарч байгаа саналуудыг бас давхар тусгах шаардлагатай байгаа юм.

Тийм учраас яг энэ салбар дээр тэд гэж нарийн тоо хэлэх боломжгүй байна. Учлаарай.

Б.Энхбаяр: Би бас П.Сайнзориг гишүүний асуултыг үргэлжлүүлж асууна.

Сая Эдийн засаг, хөгжлийн яам тооцоо судалгаан дээрээ хэлж байна. Төрийн албаны орон тоо, урсгал зардал бол сүүлийн жилүүдэд үлэмж нэмэгдсэн гэдэг асуудлыг ярьж байна.

Тэгэхээр энэ ерөнхий асуултад би Эдийн засаг, хөгжлийн яамнаас илүүтэй би Сангийн яамыг хариулаасай гэж бодож байна.

Ер нь энэ орон тоог Улсын Их Хурал руу хэн боловсруулж нэмэх асуудлыг оруулж ирээд байна вэ гэхээр салбарын сайд байгууллагуудын саналаар Сангийн яам хянаж байгаа. Улсын төсөв дээр. Би бол салбарын сайдуудыг ойлгоод байгаа. Мэдээж орон тоогоо нэмье, урсгал зардлаа нэмье, байшин саваа засъя, барилга байшин барья, тоног төхөөрөмж нэмье гэдэг ийм л салбарын эрх ашиг гэж хэлэх юм уу, дуу хоолой гэх юм уу, дандаа ийм саналууд л ирүүлнэ.

Үүнийг гол нь хянаж том зургаар нь харж байх ёстой газар бол Сангийн яам байгаа. Өнгөрсөн оны төсөв ярьж байхад маш их өөдрөг л юм яриад байсан. Сая Эдийн засаг, хөгжлийн яам хэлж байна. Орон тоо хамгийн их нэмэгдсэн салбар бол “төрийн тусгай алба” байна гэж. 70 аравны хэд гээд хэлчхэв. Өнгөрсөн хугацаанд 70 хувиар нэмэгдсэн гэж байна шүү дээ. Орон тоо нь.

Хулгай зэлгий их байна гээд цагдаагийнхаа тоог л нэмээд байсан юм байна. Цэргийнхээ тоог л нэмээд байсан юм байна. Тэгээд тэр нь буурч байсан уу, үгүй юу? Эсвэл Сангийн яам өөрсдөө хулгайчид учраас цагдаагаа авлигадаад байгаа юм уу? Чих зөөлөн болчихсон юм уу? Төмсөгдүүлчихсэн юм уу? Та нар хуулийнханд.

Хуулийнхан тэрийг нь ашиглаж, орон тоо юмаа нэмэгдүүлдэг болсон юм уу? Би бол төсвийн асуудал дээр яриад байсан юм шүү дээ. Яагаад мянган орон тоо гүйцэтгэлээр хэмнэгдэж байгаа газар дахиад шинээр мянгыг нэмээд ороод ирээд байгаа юм бэ гэдэг асуудал тавьж байсан юм шүү дээ.

Одоо бодит үнэтэйгээ нүүр тулчхаад нийтээр нь төрийн албыг 9 хувь цомхотгоё гэж яриад сууж байна. Манай Байнгын хорооны гишүүд зарим нь бараг уйлсан уу яасан. Салбарынхаа эрх ашгийг хамгаална. Манай салбарыг яах гэж байна. Орон тоог нь нэмэх ёстой. Бичиг цаасыг нь нэмэх ёстой гээд л. Сайд ч гэсэн гишүүд та нар гудамжинд гараад эргүүл хийхгүй юу гэсэн шүү дээ. Тэгж доромжилж болохгүй шүү.

Одоо бодит үнэтэйгээ нүүр тулсан. Сая Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаас би дахин асууна. Монгол Улсын шүүх 300 гаруй шүүгчтэй. Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба сая 2 жилийн өмнө 20-иодхон хүнтэй байсан шүү. Одоо 109 хүнтэй болсон гээд сууж байна.

Шүүгч нараасаа давах нь байна шүү. Энэ хурдаараа. Шүүгчдээ үйлчилдэг ажлын алба нь шүүгчийг сонгон шалгаруулах ажлыг хийдэг ажлын алба нь Монгол Улс 300 шүүгчтэй байхад 100 гараад явчихсан гэдэг чинь юу гэсэн үг юм. Нэг хүнийг сонгон шалгаруулахын тулд 10 хүн ажиллах юм уу. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг бид 10 орон тоо болгоод Үндсэн хуульдаа хийчхээд байгаа шүү дээ. Тэгэхэд ажлын алба нь 100 гараад явчхаад байгаа байхгүй юу. Энэ бол арай хэтэрч байна шүү дээ.

Та нар тэр Тасганы овооны байрандаа багтаж байгаа юм уу? Одоо шинээр байр барина гэх юм байна л даа. Ажлын албандаа шинээр хажууд нь өргөтгөл барих ёстой гэж орж ирэх гэж байна. Одоо. Багтахгүй байна гээд.

Тэгэхээр энэ урсгал зардал юм бол танагдана. Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хоёр одоо энэ дээр яг бодитойгоор та нар чадах уу, үгүй юу би мэдэхгүй байна. Та нар чадахгүй бол Их Хурал хүчээр хасна.

Төрийн урсгал зардал орон тоог хамгийн багадаа 30-аас 40 хувь хасна. Энэ бол бодит байдал. Ирэх онд манай Байнгын хороон дээр орон тоо, урсгал зардал нэмүүлэх тухай санал нэг ч орж ирэхгүй. Хасах тухай л асуудал ярина. Татвар нэмээд байдаг. Тэр татварынх нь мөнгөөр юу болоод байгаа тухай ард түмэн эсэргүүцэж жагсаж байна шүү дээ. Төр нь дүлий болчхоод байна. Төр ард түмний итгэл байхгүй болсон. Итгэл байхгүй болбол бүх юм нурж унана. Итгэлцэл байхгүй болчхоод байна.

Тийм учраас энд хууль сахиулах салбарынхан янз бүрийн байдлаар орон тоо, урсгал зардал нэмүүлэхтэй холбоотой нэг ч Улсын Их Хурлын гишүүнд лобби хийхийг зөвшөөрөхгүй. Төсвийн тодотголын үеэр урсгал зардлыг хасъя гэхэд нэг гишүүн рүү хамгийн багадаа 3 хүнээр яриулж байна лээ. Нэг хуулийн байгууллага шүү. Би үүнийг Төсвийн байнгын хорооны ажлын хэсгийн хурал дээр хэлсэн. Их Хурлын гишүүд ээ, боль оо. Ард түмнийхээ талд бай. Та нар энэ хуулийн байгууллагынхны лоббигоор бүгд төмсөгдүүлчхээгүй юм бол ингэж тансаглал юмыг нь нэмж өгдгөө боль оо гэдэг асуудлыг тавьж байсан.

Тийм учраас одоо яг энэ дээр ямар байр суурьтай байна? Би Сангийн яамнаас асууж байна. Сангийн яамнаас хэн байна. Одоо та нар яг юу гэж бодож байна. Би өнгөрсөн онд төсөв орж ирж байхад Та бүхнээс асууж байсан. Хамгийн их нэмэгдлийг Та бүхэн оруулж ирсэн. 2 мянган орон тоо байх аа. 2025 онд энэ салбар дээр 2 мянган шинэ орон тоо нэмье. Боломжтой гэж орж ирж байсан шүү та нар.

Одоо он гараад сарын дараа нүүрсний үнэ унасан чинь энэ салбарын орон тоог 9 хувь хасъя гэж орж ирж байгаа.

5 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Б.Энхбаяр даргын асуултад хариулъя.

Төсвийн зардлыг хасах асуудал дээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас ч тэр, тэгээд Засгийн газраас ч тэр гарч ирж байгаа саналуудыг Сангийн яамны хувьд бүгдийг нь дэмжсэн байр суурьтайгаар ажиллаж байгаа.

Ер нь урсгал зардлын хувьд бид энэ жилийн хувьд Засгийн газрын түвшинд Төрийн бүтээмж, хэмнэлтийн үндэсний зөвлөл гэдэг зөвлөлийн хүрээнд 2 удаа хэлэлцүүлсэн. Мөн Их Хурлын даргын захирамжаар байгуулсан Ажлын хэсэг дээр 2 удаа хэлэлцүүлчхээд байж байгаа.

Ер нь төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар хасна гэсэн энэ тоог Сангийн яамны хувьд хоёр зүйлийг эхлээд хийх шаардлагатай гэж үзэж байгаа.

Нэгдүгээрт, ер нь төрийн чиг үүрэг гэдэг маань юу вэ гэдэг энэ асуудлыгаа бид тодорхой гаргаж ирэх ёстой. Яг одоо 208 хууль, 1024 хуулийн заалтаар төсвийг ингэж ингэж ийм юманд зарцуулна, эсвэл үүнийг санхүүжүүлнэ гэсэн заалтууд байгаа юм.

Тэгэхээр эндээс бид төрийн чиг үүргээ зөв болгоод гаргаад ирэх юм бол энэ энэ салбарууд дээр ийм байдлаар явна гэдэг байдлаар орон тоог хэмнэх боломжтой гэдэг зүйлийг харж байгаа.

Төрийн тусгай албан хаагчдын хувьд, ер нь төрийн албан хаагчдын хувьд 2025 онд 230.9 мянган орон тоог бид төлөвлөж төсвийг тавьсан. Энэ нь 2016 онтой харьцуулаад харах юм бол 186.4 мянгаас 230 мянга буюу 44 мянга орчмоор нэмэгдээд байна гэсэн тоо харагдаж байна.

Яг төрийн тусгай албыг нь аваад үзэх юм бол 41.8 мянгаас 45.9 мянга буюу ойролцоогоор 4100 орчим орон тоогоор нэмэгдсэн байна. Энэ ойролцоогоор 9 хувиар юм уу даа нэмэгдсэн. Түүнээс 70 хувиар гэдэг нэмэгдлийг мэдэхгүй байна.

Хамгийн их нэмэгдсэн нь “төрийн үйлчилгээний алба” байгаа. Өөрөөр хэлбэл эмч, багш нарын хувьд шинэ сургууль барих, шинэ цэцэрлэг барих үед нэмэгдээд явдаг. 120.5 мянга 2016 онд байснаас 154.1 мянга болж байгаа. Өөрөөр хэлбэл 34 мянгаар төрийн үйлчилгээний албан хаагчид нэмэгдсэн байгаа.

Тэгэхээр энэ төрийн албан хаагчдын орон тоог бид бууруулах чиглэлээр Сангийн яамны хувьд өмнө нь хэд хэдэн арга хэмжээг авч хийж үзэж байсан. Хувийн хэвшил хийх боломжтой албыг бид жишээ нь гаргах гэж үзэж байсан. Жишээ нь, цэвэрлэгээ үйлчилгээ гэх мэт ийм албуудыг заавал төрийн албан хаагч байгаад тангараг өргөжиж хийх шаардлагагүй гэдэг асуудлаар.

Нөгөө талдаа хувийн хэвшилд байх юм бол илүү татвараа төлөөд, мөн бүтээмжээ сайжруулаад явах боломжтой байна гэдэг талаар бид хийж үзэж байсан. Гэхдээ энэ орлогууд бас тийм бүтэмжтэй байгаагүй. Тухайн үедээ шийдвэрээ гаргуулаад эхлээд явж байхад бас олон нийтийн эсэргүүцэлтэй тулаад зогсож байсан.

Тэгэхээр яг 9 хувийн энэ цомхотголыг бид хэд юу гэж хараад байна гэхээр “ТТ” дээр, “ТЗ” дээр, “ТҮ” дээр буюу салбар болгон дээр яг ижилхэн 9 хувийн таргет өгөөд, үүүнийх нь дагуу хасаа гэх юм бол энэ жинхэнэ алдаа

завхрал, нугалаа явах боломжтой гэж бид харж байна. “ТТ”-ийн хувьд асуудал нэг өөр байгаа. “ТЗ”-ийн хувьд асуудал бас нэг өөр байгаа гэдэг ийм байдлаарар анализ хийсний үндсэн дээр явах нь зүйтэй гэж үзэж байна.

Ирэх жилийн төсөв хөгжлийн төлөвлөгөөг гарсан зүйлийг ирэх жилийн төсөв биелүүлэхэд чиглэсэн байдлаар боловсруулагдах ёстой. Яг энэ цаг үед хөгжлийн төлөвлөгөөтэй зэрэгцээд төсвийн хүрээний мэдэгдэл явж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлийн зарлагын хэмжээ яг энэ жилийн төсөвтэйгөө ижилхэн байгаа. Өөрөөр хэлбэл ирэх жил бид цалин хөлсийг нэмэх, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх шаардлагатай гэж үзэх юм бол 1-ээс 1.5 их наяд төгрөгийн зарлага нэмж суулгах ёстой.../минут дуусав/

Б.Энхбаяр: Хариултыг гүйцээж өгье. 5 номер.

М.Санжаадорж: Тэгэхээр яг тэр хэмжээний зардлыг нөгөө талдаа бас хасах хэрэгтэй болчихоод байна гэсэн үг болоод байгаа юм.

Тэгээд түрүүн таны хэлдэгчлэн орлогын хувьд бас бид уул уурхай маш их эрсдэл байгаа учраас нөгөө талдаа хэмнэлт хийнэ гэдэг зайлшгүй зүйл болж байгаа.

Одоо энэ тогтоолоор бид нарт энэ эрхээ авах юм бол нөгөө талдаа бол 8 сард төсвөө нэлээд хумьсан байдлаар оруулж ирнэ гэсэн ийм байдлаар ажиллаад явж байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. П.Сайнзориг гишүүнээр тасаллаа.

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би зарчмын хувьд төрийн бүтэц данхайж байгаа энэ асуудал дээр тодорхой нөхцөл байдал үүссэн гэдэгтэй санал нийлж байгаа юм.

Тэгэхдээ энэ арга зүйгээ болон ямар үнэ тооцоо судалгаанд үндэслэж байгаа бүх зүйлүүдээ их ойлгомжтой болгохгүй бол наад мессеж чинь олон нийтэд их буруу очоод байна.

Яг анхан шатан дээр ажил хийж байгаа хүмүүс биш, тэр данхар бүтцүүд, чиг үүргийн давхардлууд. Эргээд сая Б.Энхбаяр гишүүний хэлж байгаа орон тоо хэмнэгдээд байгаа газар дахиад орон тоо нэмж өгөөд байгаа ч гэдэг юм уу. Сая жишээг аваад л ярья л даа. Шүүхийн ерөнхий зөвлөл 159-ийн орон тоогоор батлуулчихаад 109-үүл ажиллаж байгаа. 50 хүний цалинг хэмнээд үүнийг яадгийг бол мэдэж байгаа шүү дээ бид хэд. Үндсэндээ тэнд ажиллаж байгаа хүмүүс нь жилийн сүүлчээр урамшуулал болгож авдаг. Ажил хийдэггүй баахан хүмүүс. Энэ

зөвхөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн асуудал биш. Ер нь нэг ийм юм руугаа орчихлоо. Хэдүүлээ.

Тэгэхээр үүнийгээ ингээд бодит байдалдаа ойлголцохгүй бол тухайн үедээ янз бүрийн байдлаар нэг лобби хийж байгаад, энэ Улсын Их Хурлын гишүүдэд янз янзаар нөлөөлж байгаад ийм юмнуудыг батлуулсан. Ялангуяа ажлын алба гэдэг цалингийн шатлалтай газрууд.

Гэтэл өнөөдөр санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал дээр орон нутагт байцаагч нар байхгүй байгаа шүү дээ. Жишээ нь, Санхүүгийн зохицуулах хороон дээр.

Тийм ч учраас өнөөдөр хүмүүс эд мөнгөөрөө хохироод энэ нь хууль шүүхийн байгууллагын ачааллыг нэмэгдүүлж байгаа байхгүй юу. Байх ёстой газар нь жишээ нь орон тоо байхгүй байна.

Тэгэхээр үүнийгээ анхаарна биз.

Хоёрдугаарт, би бас О.Алтангэрэл сайд ороод ирсэн дээр энэ хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын цахимжилтыг нэгдсэн нэг системд оруулж явахгүй бол болохгүй.

Би Германы загварыг хэлье. Нэгдсэн нэг хуулийн этгээд байгуулаад, шүүх эрх мэдлийн байгууллага, прокурор, Хууль зүй, дотоод хэргийн яам, мөрдөгч болон өмгөөлөгч нараа төлөөлөөд ингээд бий болгодог. Бүтээгдэхүүн хаанаас гарч байна гэдэг нь мөрдөх байгууллага дээрээс гараад, энэ дээр шинжилгээний байгууллагууд оролцоод, өмгөөлөгчид нь цаг хугацаа, орон зайнаас үл хамаараад тэр хэргийн материал, хавтаст хэрэгтэй танилцаад, тэрийг нь шүүх хуралдаан дээр үзэх харах бололцоотой. Энэ нь тэгээд тус салбарынхаа тусгай архивд эцсийн байдлаар үлддэг.

Тэгээд эндэх аюулгүй байдал, дата мэдээллийг хэн хамгаалах вэ, яах вэ гэдэг асуудал байхгүй юу. Гэтэл өнөөдөр ямар нэгэн байдлаар уялдаагүйгээр тал талд төсөл хэрэгжүүлж байна. Манайхан доноруудтай уулзахаараа гоё ганган үг хэлж байгаад ерөөсөө л энэ салбарын цахимжилт гээд нэг баахан тоног төхөөрөмж авах л юм хэлдэг байхгүй юу. Тэгээд эцсийн дүндээ бүгд уялдахгүй.

Тийм учраас өнөөдөр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаасаа цахимжаад, дараагийн цахимжих хамгийн энгийн шийдэл бол захиргааны хэрэг. Тэгээд явах ёстой. Тэгээд магадгүй энэ дээрээ бид хэд алдаа оноогоо үзээд иргэн, эрүүгээ цахимжуулмаар байна.

Хоёрдугаарт, өнөөдөр бас арилжааны хууль энэ тэр Засгийн газраар орж ирж байгаа гэж байна. Бид хэд энэ арилжааны шүүх энэ тэр дээр илүү их төрөлжсөн шүүгч нараа мэргэшүүлсэн байдал руу оруулах ёстой болохоос биш энэ ачаалалгүй хэсэг дээр ингэж орон тоо нэмээд байгааг шүүх өөрөө ингэж манлайлж болохгүй шүү. Шүүх өөрөө ингэж үлгэрлэж болохгүй. Үүнийгээ ер нь цуцалчих хэрэгтэй Н.Мөнгөнцэцэг дарга аа. Би үүнийг араас нь нэхнэ. Би энэ хаврын чуулганаар хэлсэн.

Ийм байдлаараа яагаад эрүү, иргэнийхээ шүүгч нарын орон тоог нэмж чадахгүй байж захиргаан дээр нэмээд байгаа юм бэ? Энэ ямар эрх ашиг байна? Тэнд тендерийн маргаан дээр л сонирхол байна. Тийм ээ. Эсвэл ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн маргаан дээр сонирхол байгаад байгаа байхгүй юу. Үүнийгээ боль оо. Наадах чинь бүр олон нийтэд уншигдаад байна. Үүнийг хаанаасаа санал гаргаад байдаг юм. Үүнийгээ больчих хэрэгтэй.

Хоёрдугаарт, С.Эрдэнэболд дарга намайг сая гадаад төлөөлөгчтэй уулзаж байгаа учраас хэлчхээрэй гэсэн юм. Бид хоёрын хувьд Хүний эрхийн Үндэсний Комиссоос яриа яваад байгаа. Бас асуудлыг нэг ирэх жилийн жилийн хөгжлийн төлөвлөгөө болон бас юмнууд дээр анхаарчхаач ээ гэж байгаа юм.

Ер нь Монгол Улсаас олон улсын байгууллага дээр очоод амлалт өгсөн. Ази, Номхон далайн хүний эрхийн төвийг байгуулъя. Энэ төв гэдэг нь иргэдээ соён гэгээрүүлэх, энэ хүний эрхийн ойлголтоо нэгдмэл байдлаар ойлгох, олон улсын тренд хандлага нь юу болж байгааг мэдэх, олон улсын байгууллагадаа бид хийж байгаа зүйлээ зөв тайлагнаж сурах. Тэгээд энэ хүмүүсүүдээ бас чадавхжуулах асуудлыг л энэ төв дээр ярих гээд байгаа юм.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэллээ. Дууслаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд П.Сайнзориг гишүүн танилцуулчих уу? Та байдаг. Тийм ээ. Тийм. П.Сайнзориг гишүүн танилцуулчихъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрслөө мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 42 минут үргэлжилж, 12 цаг 33 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД